



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/105

Ховд

Хязгаарлалт тогтоох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх заалт, Засгийн газрын 2020 оны "Бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх тухай" 62 дугаар тогтоол, Улсын Онцгой комиссын 2020 оны 04 дүгээр тушаалыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн, сар шинийн баярыг тэмдэглэхгүй байх зорилгоор аймаг, сумын төвөөс гарах, орох иргэд, автомашины хөдөлгөөнийг 2020 оны 02 дугаар сарын 21-ний өдрөөс 2020 оны 02 дугаар сарын 26-ны өдрийг дуустал хугацаанд хязгаарласугай.

2. Иргэд болон тээврийн хэрэгсэлийн хөдөлгөөнд хязгаарлалт хийж хэрэгжилтийг хангаж ажиллахыг Онцгой комиссын орлогч Баруун бүсийн төв-Ховд аймгийн Онцгой байдлын газар /дэд хурандаа Б.Алтанбадралт/, Цагдаагийн газар /цагдаагийн хурандаа Э.Даваасүрэн/, Авто тээврийн төв /Н.Ирэхзаяа/, Жаргалант сумын Засаг дарга бөгөөд Ховд хотын захирагч /С.Гантөмөр/, сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

Zax A/105.Ch  
02 00463